

Ринчиннямьн АМАРЖАРГАЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүн

2008 онд УИХ-ын сонгуулийн 16-р тойрог Ховд аймгаас парламентад сонгогдсон. Монгол Улсын төсөв, мөнгөний бодлого, макро эдийн засаг, гадаад харилцаа, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, зэвсэгт хүчин, боловсрол, даяаршилал, чөлөөт худалдаа зэрэг асуудлуудыг төрийн бодлогын түвшинд түлхүү анхаарч ажилладаг.

- Төсвийн байнгын хорооны гишүүн
- Аюулгүй байдал, Гадаад бодлогын байнгын хорооны гишүүн
- Тусгай хяналтын дэд хорооны гишүүн
- Монгол-Их Британийн парламентын бүлгэмийн дарга
- Монгол-Люксембургийн парламентын бүлгэмийн дарга

Утга: Ховд аймагт ажилласан тайлан
Индекс: HVD/2010/02
Хаана: Булган, Үенч, Алтай, Мөст, Цэцэг, Дарви сумд 9 багийн төв
Хэзээ: 2010 оны 9 дүгээр сарын 15-наас 23-ны өдрүүд
Нэмэлт:

ТОЙМ


УИХ-ын гишүүн Р.Амаржаргал 2010.09.15-23-ны өдрийг хүртэл өөрийн сонгогдсон тойрог болох Ховд аймгийн Булган, Үенч, Алтай, Мөст, Цэцэг, Дарви сумдын 9 багийн төвд ажиллаж, иргэд сонгогчидтой уулзалт хийлээ.

Нийт 520 гаруй сонгогчидод Монгол Улсын макро эдийн засаг, аюулгүй байдал, гадаад бодлого болон нийгмийн чухал асуудлуудын хүрээнд өөрийн хийсэн ажлаа тайлагнаж, УИХ-ын 2010 оны Хаврын чуулганаар батласан бодлого шийдвэрийн талаар болон цаг үеийн асуудлаар мэдээлэл хийж, санал бодлоо солилцлоо.

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал нь 6 сумын удирдлагуудтай уулзаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй зарим төсөл, хөтөлбөр, барилга байгууламжтай танилцаж, цаашид анхаарах асуудлаар санал солилцохын зэрэгцээ Ховд аймгийн хөшөөтийн уурхайн үйл ажиллагаатай танилцав.



Багийн төв дээр
иргэдтэй хийсэн
уулзалтын үеийн болон
Хөшөөтийн уурхайн
үйл ажиллагаатай
танилцаж буй фото
зургийн агшин.



Иргэдээс банкны зээл, бүсийн нэмэгдэл, жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх, малгүй болсон айл, өрхийг малжуулах төсөл, өргөн хэрэглээний барааны үнийн нэмэгдэл зэрэг тулгамдсан асуудлаас гадна дараах 2 үндсэн асуудлыг хөндлөө. Үүнд:

1. Иргэний шинэчилсэн бүртгэл – энэ хүрээнд 1960 оноос өмнө төрсөн төрсний гэрчилгээгүй иргэд архивын лавлагаа авах, хурууны хээгээ бүртгүүлэх гэж аймаг, сумын төв зайлшгүй орох нь зардал мөнгөний хувьд хүндрэлтэй байгаа талаар,
2. Оюутны төлбөр – энэ хүрээнд хүний хөгжил сангаас их, дээд сургуулиудын оюутнуудын төлбөрийг төлөх эсэх, үүнд магадлан итгэмжлэгдээгүй хувийн их, дээд сургууль хамрагдах эсэх,

гэсэн асуудлуудыг хөндөж, УИХ-ын гишүүнээс мэдээлэл сонсож, энэ асуудал дээр анхаарч ажиллахыг захилаа.

Ажлын алба
Монгол Улс, Улаанбаатар хот
Төрийн ордон – 211

Утас: 260127, Факс: 310127
И-мэйл: info@amarjargal.org
Цахи хуудас: www.amarjargal.org